



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпын гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41
И-мэйл: moh@moh.gov.mn, http://www.moh.gov.mn

2023. 01. 19 № 6/275

танай _____-ны № _____-т

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗАР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН
ЭМНЭЛЭГ, ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН
ТӨВИЙН ДАРГА, ЗАХИРАЛ НАРТ

Эрүүл мэндийн сайдын 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн “Дархлаажуулалтын үйл ажиллагааг сайжруулах тухай” 02 дугаар албан даалгаврыг хүргүүлж байна. Албан даалгаврын хэрэгжилтийг ханган, биелэлтийгг заасан хугацаанд ирүүлнэ үү.

НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗРЫН ДАРГА

Д.БАЯРБОЛД



145223105



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
АЛБАН ДААЛГАВАР

2023 оны 01 сарын 19 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Дархлаажуулалтын үйл ажиллагааг
сайжруулах тухай

Сүхбаатар аймгийн Нэгдсэн эмнэлэгт 2022 оны 12 дугаар сарын 05-26-ны өдрүүдэд нохойд уруулсан өгүүлэмжтэй 8-56 насны 9 иргэнийг 19 удаагийн давтамжтайгаар “Сүрьеэгийн эсрэг БЦЖ вакцин”-аар тарьсан ноцтой алдаа гарсан.

Энэхүү нөхцөл байдалтай уялдуулан вакцинжуулалт болон эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, сахилга, хариуцлагыг өндөржүүлэх, дотоод хяналтыг сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахыг ДААЛГАХ нь:

Нэг. Халдварт өвчин судлалын үндэсний төв, Зоонозын өвчин судлалын үндэсний төвд:

1.1. Дархлаажуулалтын чиглэлээр ажилладаг хүний нөөцийн судалгаа гаргаж, дархлаажуулалтын мэргэжилтэн, вакцинолог сувилалч, яаралтай тусламжийн тасаг, хүлээн авах, гэмтэл, халдварын тасгийн сувилалч нарыг аюулгүй тарилгын сургалтанд хамруулах, ажлын байранд давтан сургах сургалтыг тогтмолжуулах;

1.2. Дархлаажуулалтын чиглэлээр аймаг, дүүргийн Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн газар, дархлаажуулалтын нэгжид дэмжлэгт хяналт хийх, төлөвлөлт хуваарь баталж, биелэлтийг хангуулах;

1.3. Вакцин, биобэлдмэл хэрэглэх, тооцоолох, төлөвлөх, зарцуулалтад хяналт тавих талаар орон нутагт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, нэгдсэн удирдлагаар хангах;

1.4. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба, багийн үйл ажиллагааг сайжруулан, Эрүүл мэндийн сайдын 2019 оны “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах зарим арга хэмжээний тухай” А/566, “Халдварын сэргийлэлт хяналтын үйл ажиллагааг сайжруулах тухай” А/536, А/538, А/539, “Тарилгын аюулгүй байдлын зааврыг хэрэгжүүлэх тухай” А/537, “Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах тухай” 2022 оны А/352 дугаар тушаал, эмнэлзүйн шинэчлэгдсэн зааврыг хэрэгжүүлэхэд мэдлэг олгох, дадлагжуулах сургалтыг богино хугацаанд зохион байгуулах;

1.5. Улсын хэмжээнд зоонозын халдварт өвчний чиглэлээр эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар ханган, дэмжлэг үзүүлэх;

1.6. Галзуу өвчний эсрэг хариу арга хэмжээ болон дархлаажуулалтын талаар холбогдох эрүүл мэндийн ажилтныг сургаж дадлагажуулах;

143220046

Хоёр. Аймаг, Нийслэлийн эрүүл мэндийн газар, Зоонозын өвчин судлалын төвд:

2.1. Харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган, хяналт тавьж, хариуцлагыг өндөржүүлэн ажиллах;

2.2. Дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн, вакцинатор сувилагч нарыг тогтвор суурьшилтай ажиллахад анхаарч, шинэ мэргэжилтэн, ажилтныг дархлаажуулалтын сургалтанд заавал хамруулан үйл ажиллагаанд оролцуулах;

2.3. Хүний нөөцийг мэргэшүүлэх, давтан сургах, чадавхжуулах ажлыг тогтмол зохион байгуулж, сургалтын үр дүнд хяналт тавьж ажиллах;

2.4. Вакцин хүлээн авах, тээвэрлэх, хадгалах, хэрэглэх, нөхөн хангалт хийх, устгах үйл ажиллагаанд онцгой анхаарч Эрүүл мэндийн сайдын 1997 оны А/219, 2011 оны А/122, А/359, 2015 оны “Дархлаажуулалтын тухай” А/261, 2017 оны “Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах, заавар батлах тухай” А/505 дугаар тушаал, зааврыг мөрдөн ажиллах, хэрэгжилтэд тавих хяналтыг тогтмолжуулах;

2.5. Эрүүл мэндийн сайдын 2017 оны 160 дугаар тушаалаар баталсан Зонхилон тохиолдох зоонозын халдварт өвчний хяналт, сэргийлэлтийн зааврын хэрэгжилтийг ханган ажиллах;

2.6. Зоонозын халдварт өвчний тохиолдол бүртгэгдсэн үед хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, дархлаажуулалт хийх хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах сургалтыг тогтмол зохион байгуулах;

2.7. “Нэг эрүүл мэнд” үзэл баримтлалын хүрээнд мал, амьтны дундах галзуу өвчний тохиолдлын мэдээг солилцох, галзуу өвчний эрсдэлд өртөгсдийн мэдээг 7 хоногоор гаргаж, босго үзүүлэлтийг тооцон дүн шинжилгээ хийж, хариу арга хэмжээг төлөвлөн, үндэсний түвшинд ЗӨСҮТ-д мэдээлэх;

2.8. Галзуу өвчний эсрэг вакцинжуулалтын бүрэн тунгийн хамралтад хяналт тавьж, дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийг бүртгэж, мэдээлэх;

2.9. Галзуу өвчний эрсдэлд өртөгсдийн халдварын эх уурхайг тогтоож, хариу арга хэмжээг оновчтой төлөвлөн, хэрэгжүүлэх;

2.10. Галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах;

2.11. Эзэнтэй нохойг бүртгэлжүүлэх, хүн урж, ноцсон тохиолдолд нохой эзэмшигчдэд хүлээлгэх хариуцлагыг бусад мэргэжлийн байгууллагатай хамтран шийдвэрлэх, эзэнгүй нохой, муур устгах арга хэмжээг зохион байгуулж ажиллах саналыг төрийн болон нутгийн захиргааны байгууллага, бүх шатны Мал эмнэлгийн байгууллагад хүргүүлэх;

Гурав. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт:

3.1. Эрүүл мэндийн сайдын 2019 оны “Эрүүл мэндийн салбарын статистик мэдээ, мэдээллийн журам, бүртгэлийн маягтыг шинэчлэн батлах тухай” 611 дүгээр тушаал, Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5095:2017 стандартын 12 дахь заалтын дагуу эмч, эмнэлгийн ажилчид өвчний түүх, хяналтын карт, анхан шатны бүртгэл, маягтыг зааврын дагуу үнэн, зөв хөтөлж, хяналт тавих;

3.2. Вакцин хүлээн авах, тээвэрлэх, хадгалах, хэрэглэх, нөхөн хангалт хийх, устгах үйл ажиллагаанд онцгой анхаарч Эрүүл мэндийн сайдын 1997 оны А/219,

2011 оны А/122, А/359, 2015 оны “Дархлаажуулалтын тухай” А/261, 2017 оны “Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах, заавар батлах тухай” А/505 дугаар тушаал, зааврыг мөрдөн ажиллах, хэрэгжилтэд тавих хяналтыг тогтмолжуулах;

3.3. Эрүүл мэндийн сайдын 2017 оны 160 дугаар тушаалаар баталсан Зонхилон тохиолдох зоонозын хардварт өвчний хяналт, сэргийлэлтийн зааврын хэрэгжилтийг ханган ажиллах;

3.4. Монгол Улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 116/А/565 дугаар тушаалын хэрэгжилтийг ханган, тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах, стандарт, эмнэлзүйн зааврыг мөрдүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж үр дүнг тооцож ажиллах;

3.5. Сувилахуйн тусламж үйлчилгээнд эмнэлзүйн аудитыг хийх, сувилагчийн гардан үйлдэл, ээлж хүлээлцэх, эм, тариа, вакциныг тээвэрлэх, хүлээн авахтай холбоотой эмнэлзүйн бүх харилцаанд аюулгүй байдлын зарчмыг мөрдлөг болгон эмнэл зүйн удирдамж, заавар, стандартын дагуу явагдаж буй эсэхэд тогтмол дэмжлэгт хяналт, тохиолдолд суурилсан хэлэлцүүлэг, чанарын дотоод хяналтыг хийж тогтмолжуулах;

3.6. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба, багийн үйл ажиллагааг сайжруулан, Эрүүл мэндийн сайдын 2019 оны “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах зарим арга хэмжээний тухай” А/566, “Халдварын сэргийлэлт хяналтын үйл ажиллагааг сайжруулах тухай” А/536, А/538, А/539, “Тарилгын аюулгүй байдлын зааврыг хэрэгжүүлэх тухай” А/537, “Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах тухай” 2022 оны А/352 дугаар тушаал, эмнэлзүйн шинэчлэгдсэн зааврыг хэрэгжүүлэх мэдлэг олгох, дадлагжуулах сургалтыг богино хугацаанд зохион байгуулах;

3.7. Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой гарсан тохиолдол, эрсдэлийг зэмлэн буруутгахгүй аргаар бүртгэх, шуурхай хариу арга хэмжээ авах соёлыг эрүүл мэндийн байгууллага бүр хэрэгжүүлж Эрүүл мэндийн хөгжлийн төвийн “Тохиолдол мэдээллэх нэгдсэн сан”-д мэдээлж хэвших;

Дөрөв. Албан даалгаврын хэрэгжилтийн явцын талаарх мэдээллийг 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн дотор, гүйцэтгэлийн тайланг 2023 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн дотор Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газарт ирүүлэхийг Халдварт өвчин судлалын үндэсний төв, Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга, захирал нарт үүрэг болгож байна.

САЙД  С.ЧИНЗОРИГ

